

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 07 дугаар сарын 10-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Засварын газрын иж бүрдэл багаж хэрэгсэл**
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012148

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **Засварын газрын иж бүрдэл багаж хэрэгсэл** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөгөөр цахим систем ашиглан худалдан авах боломжтой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт **1 360 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:10 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 505 тоот өрөө, утас: 450060 + 180

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ